НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

# СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

Нийслэлийн Соёл, урлагийн газрын
2019 оны.... дугаар сарын ...-ны өдрийн ...
тушаалын хавсралт

# НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

## Хөтөлбөрийн зорилго

Нийслэлийн Соёл, урлагийн газрын ажилтан, албан хаагчдын мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, мэргэшсэн тогтвортой байдлыг хангах, тэдний хөгжүүлэн мэргэшүүлэх төрөл бүрийн сургалтад хамруулах, давтан сургалтыг зохион байгуулах, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, чадваржуулах, улмаар тэдний мэдлэг, чадвар нь тулгуурлан албан тушаалд томилох, дээшлүүлэх, албан хаагчийн мэдлэг, хөрвөх ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэхэд энэ хөтөлбөрийн зорилго оршино.

## Нэг. Нийтлэг үндэслэлт

Төрийн байгууллагын хүний нөөцийн менежментийн хувьд төрийн албан зөвхөн чадвартай мэргэшсэн, хөрвөх чадвартай байх зарчмыг баримтлаж байгууллагын албан хаагчдын мэргэжил, ур чадварыг сайжруулах үндсэнд төрийн байгууллагын ажил үйлчилгээг чанаржуулах, үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага тулгараад байгаа билээ. Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоол, "Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай", Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам", Байгууллагын дотоод журам, Байгууллагын дүрэм, Байгууллагын стратеги төлөвлөгөө, Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, бусад холбогдох хууль тогтоомжид заасныг үндэслэн албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулав.

## Хоёр. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

2.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн Соёл, урлагийн газрын дэргэд судлаачдын зөвлөл байгуулан ажиллаж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох болон үйл ажиллагааг нь зохицуулсан журмыг тус газрын даргын тушаалаар батална.

2.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, жил бүр хэрэгжилтийн явцыг гаргаж тайлагнах үүргийг Соёлын хэлтэс хамтран хэрэгжүүлнэ.

2.3 Нийслэлийн Соёл, урлагийн газрын үйл ажиллагааны онцлог болон эзэмшсэн мэргэжлээс хамаарч гадаад, дотоодын сургалтад хамрагдсан мэдлэг, чадвар, туршлага сайтай албан хаагчдаас сонгон шалгаруулж тус газар, харьяа соёлын байгууллагууд болон бусад байгууллагуудад сургагч-багшаар ажиллаж онол, арга зүйн зөвлөгөө өгч ажиллуулж болно. Сургагч- багшийг байгууллагын газрын даргын тушаалаар томилж урамшуулал олгож болно. Сургагч-багш нь хууль тогтоомж, дүрэм журам, эрх зүйн актуудыг судалсан өөрийгөө байнга хөгжүүлдэг, тухайн салбартаа мэргэшсэн албан хаагч байна.

2.4 Байгууллагын удирдлага нь албан хаагчийг сургах, давтан сургах, удирдлагын академийн багцын сургалтад хамруулах, хөгжүүлэх, чадавхийг нь бэхжүүлэх нөхцөлөөр хангаан дэмжлэг үзүүлэх, албан хаагч нь өөрсдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, бусад албан хаагчдын мэдлэг чадварыг сайжруулахад хамтран ажиллах үүргийг тус тус гүйцэтгэнэ.

2.5 Жил бүр сургалтын төлөвлөгөө гаргаж, байгууллагын даргаар батлуулан ажиллана.

Гурав. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны зарчим, чиглэл

3.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчим, чиглэлийг баримтлана.

- Захирах, захирагдах ёс
- Ил тод байх
- Төрийн алба мэргэшсэн тогтвортой байх
- Төрийн албан хаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, баталгааг хангах
- Хууль дээдлэх

3.2 Сургагч-багш болон чадавхийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах

3.3 Ижил төрлийн төрийн байгууллага болон гадаад орнуудын чиг үүрэг адил бүхий албан байгууллагуудын сургалтын хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа сургалтын туршлагыг судлах, энэ чиглэлийн хамтын ажиллагааг идэвхижүүлэх;

3.4 Байгууллагын хүний нөөц нь сургалтын хэрэгцээ шаардлагыг судалж нэгжийн даргад танилцуулна. Сургалтын хэрэгцээ шаардлагын үндсэн дээр тухайн жилийн сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажиллана. Сургалтын төлөвлөгөөний дагуу шаардагдах зардлыг зарцуулан ажиллана.

3.5 Төрийн болон Төрийн бус байгууллагын сургалтыг тухайн жилд 1-2 удаа тогтмол зохион байгуулж хэвших;

*3.6 Албан* хаагчдын сурах эрмэлзлэлтэй, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, арга замыг нээлттэй байлгах;

*3.7 Сургалт*, судалгааны цогц мэдээллийн баазтай болох

- Сургалтын материал, гарын авлага, ном товхимол, газрын холбогдох хууль, эрх зүйн акт мэргэжлийн үг хэллэгийг тайлбарласан толь бичиг зэргээр баяжуулсан бичиг номын сантай болох / Цахим хэлбэрээр байж болно/
- Сургалтын материаллаг бааз, шаардлагатай техник тоног төхөөрөмжтэй болох

3.8 Сургагч -багшийг гадаад, дотоодын болон судалгааны ажилд өргөн оролцуулж, дадлага туршлагатай багш нарын туршлагаас суралцах бололцоогоор хангах замаар мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

3.9 Сургалтыг уламжлалт лекцийн сургалт, асуудал дэвшүүлэх харилцан ярилцах бүтээлч байх зэрэг сургалтын аргуудыг өргөнөөр хэрэглэж, гарын авлага, тараах материалаар хангах;

3.10 Алсын зайн сургалтыг зохион байгуулах;